

## ГАРЧИГ

<b>ОРШИЛ</b> .....	2
<b>I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
<b>II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	6
<b>III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .	8
<b>IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	9
<b>V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	11
V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	11
V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	12
V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө .....	13
V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	13
V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	13
V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14
V.8 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	14
V.9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	15
V.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
V.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	18
V.12 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	19
V.13 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....	21
<b>ДҮГНЭЛТ</b> .....	22
<b>АШИГЛАСАН ХЭВЛЭЛ</b> .....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга .....	3
Хүснэгт 2.	Уурхайн солбилцол .....	4
Хүснэгт 3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
Хүснэгт 4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	13
Хүснэгт 5.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 6.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	15
Хүснэгт 8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
Хүснэгт 9.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	18
Хүснэгт 10.	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	20
Хүснэгт 11.	Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал.....	21

## ОРШИЛ

---

“Цээцээ импекс” ХХК-ийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөөт ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 11.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

## I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**Төлөвлөгөөний нэр:** Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** “Цээцээ импекс” ХХК

**Төслийн зорилго:** Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын барилгын чулууг олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга*


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Цээцээ Импекс” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011137041	
3	Уурхайн нэр	Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар
5		Сум/Дүүрэг	Хан-Уул
6	Ашигт малтмалын төрөл	Барилгын чулуу	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	19/M017 (MV-11000099)	
8	Ашиглалт эхэлсэн огноо	2019	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Чингэлтэй
11		Баг/Хороо	19-р хороо
12		Гудамж/Байр	Шадивлан 1, 90 тоот
13		Гар утас	91915431
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Э.Гантуяа
15		Гар утас	89055431
16		Электрон шуудан	<a href="mailto:Tseestee_impex@yahoo.com">Tseestee_impex@yahoo.com</a>

**Төслийн байршил:** “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
- Ордын нэр: "Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Барилгын чулуу
- Трапецийн номенклатур: L-48-10
- Талбайн нийт хэмжээ: 54.07 га

Хүснэгт 2. Уурхайн солбицол

№	Газарзүйн солбицол			Уртраг		
	Өргөрөг					
1	106	44	11.02	47	48	58
2	106	43	49.59	47	48	58
3	106	43	39.7	47	48	50.87
4	106	43	40.95	47	48	40.65
5	106	43	36.01	47	48	40.63
6	106	43	32.78	47	48	49.15
7	106	43	30.35	47	48	51.35
8	106	43	22.44	47	48	52.19
9	106	43	15.21	47	48	50.57
10	106	43	13.7	47	48	42.09
11	106	43	11.15	47	48	42.56
12	106	43	5.89	47	48	47.97
13	106	43	2.95	47	48	48.52
14	106	43	0.96	47	48	42.73
15	106	42	59.27	47	48	42.06
16	106	42	50	47	48	42.06
17	106	42	50	47	48	40
18	106	44	11.3	47	48	40



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

**Орд ашиглах тусгай зөвшөөрөл:** Нийслэлийн засаг даргын тамгын газраас “Цээцээ импекс” ХХК-д 54.07 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож 19/М017 дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 02 сарын 12-ны өдөр олгосон байна.

**Уурхайн одоогийн байдал:** анх “Цээцээ импекс” ХХК нь Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2019 онд батлуулсан бөгөөд түүнээс хойш В-4, В-5, В-6 блокоос нийт 606.9 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлосон байна.

**Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:** Ил уурхайн хүрээнд бодитой В зэрэглэлээр 13,485.6 мян.м<sup>3</sup>, боломжтой С зэрэглэлээс 728.93 мян.м<sup>3</sup> барилгын чулуу ил уурхайн хүрээгээр өртөгдөж олборлогдоно. Нийт ил уурхайн хүрээн дотор 13,485.58 мян.м<sup>3</sup> барилгын чулуу, 791.6 мян.м<sup>3</sup> хөрс орж байна.

**Ил уурхайн талбай:** Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн ашиглалтаар 2 ухааш үүснэ. Талбай-1 дэх ил уурхай ойролцоогоор 800 м урттай, 350 м өргөнтэй байх бөгөөд 18.3 га талбайг хамарсан ухааш үүсэх бол талбай-2 дахь ил уурхай ойролцоогоор 640 м урттай, 390 м өргөнтэй байх бөгөөд 23.8 га талбайг хамарсан ухааш болох юм.

**Ил уурхайн гүн:** Ил уурхайн ёроолын түвшин талбай-1 хувьд +1340м бол талбай-2 хувьд +1360 м байх бөгөөд ил уурхайн хамгийн их гүн нь харгалзан 63м, 70 м байна.

**Төслийн хүчин чадал:** 2024 оны төлөвлөгөөгөөр бүрэн хүчин чадлаараа буюу 525.0 мян.м<sup>3</sup> хүчин чадалтай ажиллана. Орд нь жилд цэвэр 211 хоног ажиллах бөгөөд хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

**Уурхайн 2024 оны уулын ажлын төлөвлөлт:** 2024 онд 525.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлож 33.44 мян.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийнэ. Ил уурхай нь +1430 м түвшин хүртэл олборлож 2.4 га талбайг хамарсан байна.

**Тэсэлгээний ажил:** Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO”, “Аянга” зэрэг энгийн найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээний ажлыг 7 хоногт 1 удаа тогтсон өдрөөр хийх бөгөөд тэсэлгээний аюулгүй ажиллагааны зай 300 метр байна.

## II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Ландшафт:** “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” нь Газарзүйн мужлалаар ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харъяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэлд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй.

**Газарзүйн байрлал, газрын гадарга:** Талбайн хойд, баруун хойт хэсгээр жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг.

**Уур амьсгал, агаарын чанар:** Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Хамгийн хүйтэн үе нь 1-р сард  $-38^{\circ}\text{C}$ , дулаан нь 7-р сард  $+33^{\circ}\text{C}$  хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 230-350 мм-с хүрдэг, түүний 60-70% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 30-40% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг. Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 5-9 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

**Усан орчин:** Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын дүүргээр Туул, Бүхэг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг бөгөөд эдгээр голуудын гольдролын өргөн нь 30-70 м, гүн нь 0.5-1.5 м, урсгалын хурд дунджаар 1.0-1.6 м/сек гэж өмнөх судлаачид тогтоосон байна.

Ордын дүүргийн талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

Судалгааны талбайн ойр орчимд олон тооны булаг шанд, гүний өрөмдмөл худаг байдаг бөгөөд энэ нь унд ахуйн хэрэглээний усны хэрэгцээг хангадаг. Тусгай зөвшөөрөлтэй “Сондуулт” талбайд ямар нэгэн булаг шанд, өрөмдмөл худаг байдаггүй бөгөөд хийсэн хайгуулын ажлын явцад уст давхарга илрээгүй.

**Хөрсөн бүрхэвч:** Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг, нимгэн хар хүрэн, уулс хоорондын хөндийгөөр хар хүрэн тогтворжино.

**Ургамлан нөмрөг:** Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.



**Амьтан:** Уулархаг хэсгээрээ шинэс, хуш, нарс зэрэг модод ургахаас гадна ой модтой уулархаг газартаа баавгай, чоно, булга, бор гөрөөс, талархаг газартаа тарвага, хярс, үнэг, зурам, огтоно, жигүүртнээс шаазгай, шар шувуу, хэрээ зэрэг ан амьтантай ба олон төрлийн шавьж байсан. Туул голдоо зэвэг, хадран, тул зэрэг агнуурын загастай байсан.

**Түүх соёлын дурсгалд газрууд:** Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

**Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт:** Улаанбаатар хотод монгол улсын бараг тэн хагас хүн ам буюу 1,596.3 мянган хүн (2022 оны байдлаар) амьдран суудаг бөгөөд үүнээс Хан-Уул дүүрэг нь 16 хороотой бөгөөд нийт 63.9 мянган өрхөд 238.5 мянган хүн амьдран суудаг. Эдийн засгийн хувьд төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харьяалагдана.

Хан-Уул дүүрэг нь 12.0 мянга гаруй аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой бөгөөд 46.0 мянга гаруй толгой малтай, 321.3 мянга гаруй тахиа, 50.7 мянга гаруй гахай бүхий эрчимжсэн аж ахуйтай, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс нутаг юм.

Хан-Уул дүүрэг нь 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

Жилийн аль ч улиралд авто замын тээврээр уг талбайн аль ч хэсэгт зорчин очих боломжтой. Сүүлийн жилүүдэд геологийн судалгаагаар үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн олон ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, автозамын болон барилгын хайрга, дайрга олборлох карьерийн аж ахуйнууд үйл ажиллагаагаа эрхлэн асфальт, бетон зуурмаг үйлдвэрлэж байна.

### III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, бутлах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

**Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх, бутлуурт орж буй чулуулаг дахь тоос агаарт дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

**Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

**Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

**Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

**Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл:** “Цээцээ импекс” ХХК–ний ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс, түүнтэй холбоотой эд өлгийн зүйлс илрээгүй байна.

Олборлолтын явцад түүх эд өлгийн олдвор олдсон тохиолдолд холбогдох Төрийн байгууллагад мэдэгдэн хамтран ажиллах шаардлагатай.

**Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:** Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр нэмэгдүүлэх, нийслэл хотын барилга зам гүүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг түүхий эдээр хангах зэрэг эерэг нөлөөлөл байна.

**Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:** Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.



## IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:** Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

**БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл:** Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

**БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга:** Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах,

шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

#### **Байгаль хамгаалах төлөвлөгөө:**

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

#### **Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:**

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

**БОМТ-ний бүтэц:** БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

## V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	
<b>Газрын гадаргуу хөрсөнд үзүүлэх нөлөөлөл</b>						
1	Хөрс хуулалт, хөрсний овоолгоос газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх, эвдрэх	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх			Үйл ажиллагааны туршид	Барилгын чулуун ордыг ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага” MNS5917:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага” MNS5916 :2008 Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд: MNS3298-91, Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох: MNS3310-918, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ: MNS5850-2019
2	Уул уурхайн үйл ажиллагаанаас өнгөн хөрс эвдрэх, доройтох	Өнгөн хөрсийг 0.2 см зузаантай хуулах, овоолго хийх		ТНС-н зардалд орсон.		
3	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Үйлдвэрлэлийн технологийн замын зураг гаргаж зөвхөн заасан замаар машин техникүүдийг зорчуулах, Лицензийн талбай доторх замыг тэмдэгжүүлэх		100,000.0	Жил болгон /эвдэрсэн тохиолдолд засварлана/	
4	Машин техникийн засвар үйлчилгээ бусад үйл ажиллагаанаас хөрс бохирдуулах	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэх	-	1,000,000.0	Жил бүр	
5	Хөрс доройтох, цөлжих эсэх	Эвдрэлд орсон талбайд биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд	БНС-н зардалд орсон.	Үйл ажиллагааны туршид	
6	Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбайд	-		
7	Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал	Уурхайн замд	1,000,000.0		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	
<b>Ургамлын төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл</b>						
8	Ургамлын бүтэц бүрэлдэхүүнд нөлөөлөх эсэх	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд үйл ажиллагаа дуусахад	БНС-н зардалд орсон	Үйл ажиллагааны туршид нэг удаа	2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ургамал хамгааллын тухай 1995 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн байгалийн ургамлын тухай хууль
9	Ургамлын биомассд нөлөөлөх эсэх	Тоос үүсэх талбайг услах	Уурхайн зам-0.74 га	Усалгааны зардалд орсон	Байнга	
10	Ургамлын тусгаг бүрхцэд нөлөөлөх эсэх	Олон салаа зам гаргахгүй байх, Гол замд тэмдэглэгээ хийх	Уурхайн талбайд	100,000.0	Үйл ажиллагааны туршид нэг удаа	
<b>Усан орчинд үзүүлэх нөлөөлөл</b>						
11	Гүний усны нөөцөд нөлөөлөх эсэх. Хөрсний усыг бохирдуулахгүй байх	Усны хэмнэлттэй ашиглах, усыг дахин ашиглах	-	Дотоод төлөвлөлтөөр зохицуулах-	Үйл ажиллагааны туршид	-Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол ) -Усны тухай хууль, -“Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982
12	Хүнд машин механизмын нөлөөгөөр Nox, CO, Sox хийгээр агаар орчныг бохирдуулах	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	-	350,000.0	Жил бүр	
<b>Бусад</b>						
13	Байгалийн үзэсгэлэнт төрх	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр орон нутгийн удирдлагын заасан газар мод, бут, сөөг тарих	Жилд 1 удаа	Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний зардалд орсон	Үйл ажиллагааны туршид нэг удаа	
<b>Нийт зардал</b>				<b>2,550,000.0</b>		

## V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн ТЭЗҮ болон БОННУ-д тусгасны дагуу ашиглалтын хугацаанд 28 дахь жил хүртэл нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.

### V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	6	7	8
1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон газарт мод тарьж ургуулах ажлыг хийж гүйцэтгэх	-	-	3,000,000.0	2024 онд	МУ-ын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
<b>Нийт</b>					<b>3,000,000.0</b>		

### V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд 2024 онд 100 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр тусгаж өгсөн бөгөөд тус ажлын зардлыг **1,500,000 төгрөг** байна гэж тооцов.

### V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

### V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Барилгын чулууны ордын эзэмшлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

## V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	5	6	7	
1.	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны туршид	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17)
2	сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны туршид	-MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхой-лолт, ерөнхий ангилал
3		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайд	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд	
4		Уурхайн цогцолборын эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Далан байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	
<b>Нийт</b>				<b>Үйл ажиллагааны зардал</b>		

## V.8 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Цээцээ Импекс” ХХК-ийн “Морин-Уул” барилгын чулууны орд нь тэсэлгээний ажилд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” “Аянга” зэрэг эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан ашигладаг. Тэсрэх материал тэсэлгээний хэрэгслийг хотын ойролцоо орших агуулахаас зөөж тээвэрлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий тэсэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Пауэр бласт" ХХК-р хийлгэхээр төлөвлөж байгаа бөгөөд 1 удаагийн тэсэлгээнд шаардагдах тэсрэх бодис, материалыг холбогдох байгууллагууд түүний агуулах үйлдвэрээс худалдан, тээвэрлэн авч ирж тэсэлгээг хийнэ.

Хүснэгт 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хариуцах эзэн	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
---	----------------------------------	--------------------------------------------	---------------	---------------------	--------------------------------	-----------------------------





1	2	3	4	5	6
1	Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх	“Пауэр Блест” ХХК	“Пауэр Блест” ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүнд багтана.	2024 онд	-Галын аюулгүй байдлын тухай хууль -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль -Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
2	Тэсрэх бодисыг хадгалах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх				
3	Тэсрэх бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг бэлтгэж бэлэн болгох				
4	Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн талбайд булшлах, устгах арга хэмжээ авах				
<b>Нийт</b>			<b>Үйл ажиллагааны зардал</b>		

#### V.9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Цээцээ импекс” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	7	8	9	
1.	Ахуйн	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Уурхайн ажилчид	360,000.0	Үйл ажиллагааны туршид	-Хог хаягдлын тухай хууль
2.		Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах	Уурхайн талбайд	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
3		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	Хог хаягдлын цэгт	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
<b>Нийт</b>			<b>360,000.0</b>			

## V.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Цээцээ импекс” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Уг ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОХТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Цээцээ импекс” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин, аялал жуулчлалын яам)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналтын шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналтын шинжилгээний ажлын хэмжээ	Зардал /мян.төг/ 1 дэх жил	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
1	2	3	3	4	5	6	7
<b>Агаарын орчин</b>							
1	TSP	Уурхай, ажилчдын байр орчим, хог хаягдлын цэг, зам талбай	Уурхайгаас	Жилд 2 удаа	200,000.0	-MNS 17.2.316-88 Хот суурин газрын агаарын чанарыг хангах -MNS 3384:82 агаар мандлын сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS 5585:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага	24 цагийн дундаж-100
2	PM <sub>10</sub>						Жилийн дундаж-500
3	PM <sub>2.5</sub>						24 цагийн дундаж-50
4	NO <sub>2</sub> /азотын давхар исэл						Жилийн дундаж-25
5	SO <sub>2</sub> /хүхэрлэг хий						20 минутын дундаж-85
							24 цагийн дундаж -40
							Жилийн дундаж-30
							10 минутын дундаж-500
							20 минутын дундаж -

№	Хяналтын шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналтын шинжилгээний ажлын хэмжээ	Зардал /мян.төг/ 1 дэх жил	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
	1	2	3	4	5	6	7
6	СО/ нүүрстөрөгчийн дутуу исэл						450 4 цагийн дундаж - 20 Жилийн дундаж-10 30 минутын дундаж - 60000 1 цагийн дундаж- 30000 8 цагийн дундаж- 10000
7	Дуу чимээ	Уурхай		Үйл ажиллагааны туршид	330,000.0		16 цагийн дундаж 60 8 цагийн дундаж 50
<b>Хөрс</b>							
8	Механик бүрэлдэхүүн	%	Уурхайн үйлдвэрийн талбайн ойролцоо Үржил шимт хөрсний овоолго Ажилчидын сууц болон уурхайн карьер холбосон замын орчимд	Хавар, 6-р сард	205,000.0	- УСТ 3298-90 Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага - УСТ 3297-91 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлт - MNS 5850-2019-Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ	Хэмжилтээр
9	Ялзмагт үеийн зузаан	см					Хэмжилтээр
10	Ялзмаг	%					Хэмжилтээр
11	Карбо нат	%					21
12	Нефтийн бүтээгдэхүүний агууламж	мг/100 гр					5.9
13	Хүнд элементийн бохирдол	мг/100 гр					1.8
14	Бусад бохирдлын үзүүлэлтүүд	мг/100 гр					Хэмжилтээр
<b>Ус</b>							
15	Нийт хатуулаг	Н	Ундны усанд	Жилд 2 удаа /хавар, намар/	92,000.0	Гадаргын усны цэврийн зэрэглэлийн норм Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352 тоот тушаалын 3-р хавсралт	<10
16	Хлорын ион /Cl/	Мг/л					<50
17	Сульфатын ион /SO4/	Мг/л					<50
18	Натрийн азот (NO <sub>2</sub> <sup>-</sup> )	Мг/л					<0.002
19	Нитрат азот (NO <sub>3</sub> )	Мг/л					<1
20	(CO <sub>3</sub> <sup>-</sup> )	Мг/л					

№	Хяналтын шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналтын шинжилгээний ажлын хэмжээ	Зардал /мян.төг/ 1 дэх жил	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
	1	2	3	4	5	6	7
21	(HCO <sub>3</sub> <sup>-</sup> )	Мг/л					6.5-8.0
22	Устөрөгчийн илтгэгч /РН/	Мг/л					
23	Үнэр	Чанарын үнэлгээгээр					
24	Амт	Чанарын үнэлгээгээр					
25	Өнгө	Чанарын үнэлгээгээр					
<b>Нийт</b>					<b>827,000.0</b>		

#### V.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Үйл ажиллагаандаа техник, технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

#### Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт ба аргачлал, тайлбар
	1	2	3	4	5	6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Байнга	“Цэцээ импекс” ХХК	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид	500,000.0	Жил бүр	“Цэцээ импекс” ХХК	-Шуугианы норм, аюулгүй

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт ба аргачлал, тайлбар
1	2	3	4	5	6	
3.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	“Цээцээ импекс” ХХК	ажиллагаа-ны ерөнхий шаардлага -MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. –жил бүр Шуугианаас - хамгаалах хэрэгсэл ба аргууд
4	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Барилгын чулууны орд	3,000,000.0	2 жилд нэг удаа	“Цээцээ импекс” ХХК	
5	Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Барилгын чулууны орд	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	5 жилд нэг удаа	“Цээцээ импекс” ХХК	
6	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жилд бүр	“Цээцээ импекс” ХХК	
7	Ажилчидыг хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	“Цээцээ импекс” ХХК	
<b>Нийт</b>			<b>3,500,000.0</b>			

### V.12 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Цээцээ импекс” ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч “Цээцээ импекс” ХХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг
2	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	-
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	Засаг даргын тамгын газар



### V.13 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 11. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,550,000.0
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,000,000.0
3	Тэрбум мод тарих төлөвлөгөө	1,500,000.0
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
4	Химийн бодисын менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	827,000.0
7	БОМТ-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3,500,000.0
8	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
<b>Нийт</b>		<b>11,737,000.0</b>

“Цээцээ Импекс” ХХК-ний Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 11.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

## ДҮГНЭЛТ

---

“Цээцээ импекс” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 11,737,000 төгрөг гарахаар тооцоолсноос 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

---

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2024 он
7. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ыг ашиглах ТЭЗҮ 2023 он
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
9. <http://www.legalinfo.mn>